

**“ТҮШИГ-УУЛ” ХК –ний
хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл**

2019.04.30

Дархан хот

Ээлжит хурал 2019 оны 04 дүгээр сарын 30-нд Дархан Уул аймаг Дархан сум 3-р багц өөрийн байранд болов.

Тооллогын комисс хувьцаа эзэмшигчдийн ирцийг бүртгэв.

Хуралд :

1. Ж.Баяраа /рд: ТЖ62062018/ 830800 ширхэг хувьцаа эзэмшигч буюу 19.12%
2. Ж.Батсайхан /рд: ТВ71041516/ 869120 ширхэг хувьцаа эзэмшигч буюу 20.0%
3. Ж.Баянтөр /рд: ТВ64012611/ 869050 ширхэг хувьцаа эзэмшигч буюу 20.0%
4. Л.Ганчимэг /рд: ТЕ61032565/ 868030 ширхэг хувьцаа эзэмшигч буюу 19.97%

Тооллогын комиссын дарга Б.Эрдэнэтүяа хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд 3437000 ширхэг хувьцаа эзэмшдэг 4 хувьцаа эзэмшигчид өөрийн биеэр хуралд оролцохоор ирсэнг бүртгэв.

Нийт саналын эрх бүхий энгийн хувьцааны 79.09 хувь болж байгааг Хурлын даргад мэдээлж хувьцаа эзэмшигчдийн хурлыг Компаний тухай хуулийн 69.1 дэх хэсгийн үндэслэн ээлжит хурлыг хүчин төгөлдөрт тооцон тогтоолыг үншиж танилцуулав.

Хурлын дарга Ж.Батсайхан: за өнөөдөр хуралд ирсэн та нарт энэ өдрийн мэндийг хүргэе. Хурлаар хэлэлцэх асуудал болон хурлын дэгийг танилцуулав.

Хурлаар хэлэлцэх асуудал бол 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ын гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах, мөн компаний ТУЗ-ын гишүүдийг чөлөөлөх сонгох тухай хэлэлцэнэ.

За “Түшиг –Уул” ХК-ын 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ын гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлахын 2018 оны үйл ажиллагааны тайланг танилцуулав /тайланг хавсаргав/

Тайлангтай холбоотой санал асуулга:

Ж.Баяраа: үйлдвэрийн засвар үйлчилгээг цаг алдалгүй хийж бүтээгдэхүүн олборлолтыг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Хүн хүч нэмэгдүүлэн ажиллах тал дээр санаачлагатай байх хүний нөөцийн бодлого явуульяа. Ингээд 2018 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ын дүгнэлтийг батлахыг дэмжиж байна.

Ж.Батсайхан: 2018 онд үйлдвэрийн гол тоног төхөөрөмж болох земснарядын гол удаа дараа хугарч гэмтэл гарсны улмаас төлөвлөж байсан хэмжээндээ хүртэл ажиллаж чадсангүй ээ. 2019 оны төлөвлөгөөг засварыг чанартай хийж байна. Өөрийн төмөр замын дэр мод сумын дүнзийг захиалан хийлгэж байна.

Ж.Баянтөр: 2019 онд Гүйцэтгэх удирдлага алдагдалтай ажилласандаа дүгнэлт хийж ноон бололцоогоо бүрэн ашиглаж ажиллахыг хүсье. Харилцагч компаниудаа чанартай бүтээгдэхүүнээр найдвартай хангаж байх нь бидний гол зорилго юм. ТУЗ-ын дүгнэлтийг дэмжиж байнаа.

Ж.Батсайхан: бидний борлуулт жилээс жилд нэмэгдэж байгаа. Манай ажилд гол нөлөөлдөг УБТЗ-ийн воган хэрэгцээ хангалтгүй хэвээр байгаа учраас харилцагч нэмэх боломж муу байна.

Л.Ганчимэг: 2018 оныхоо алдаанд дүгнэлт хийж аль болох бүтээмжээ нэмж ажиллахыг гүйцэтгэх удирдлагаас шаардаж байна.

Ж.Батсайхан: за санал асуулга дууссан бол санал авах хуудсаар зөвшөөрсөн саналын саналын тоогоор саналаа хураая.

Тооллогын комиссын дарга Б.Эрдэнэтуяа: Хувьцаа эзэмшигчдийн зөвшөөрсөн санал нь компаний тухай хуулийн 63 дугаар зүйлд заасан хурлын шийдвэр хүчин төгөлдөр болох хувьд хүрсэн тухай, хурлын шийдвэрийг батлах тогтоолын төслийг хувьцаа эзэмшигчдэд танилцуулав. Зөвшөөрсөн 3437000 ширхэг хувьцаа буюу 79.09 хувиар батлав.

Ж.Батсайхан тогтоолыг танилцуулав.

1. Тогтоол -1 " Түшиг-Уул " ХК-ны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг талаарх ТУЗ-ын дүгнэлтийг баталсугай.

2019 онд үйл ажиллагааг эрчимжүүлж, үйлдвэрийн тоног төхөөрөмж засвар үйлчилгээг сайжруулах, хөрөнгө оруулалтын ажлыг санаачлан идэвхтэй ажиллахыг Гүйцэтгэх захирал Ж.Батсайханд даалгав.

Ж.Батсайхан: за ээлжит хурлаар хэлэлцэх 2 дах асуудал бол ТУЗ-ын гишүүдийг сонгох сонгох тухай асуудал байгаа. Миний санаа бол энэ жил улируулан сонгон ажиллуулах саналтай байна. Галарын санал ямар байна.

Ж.Баянтөр: хараат бус гишүүнээр Б.Цолмонгэрэлийг сонгох саналтай байна.

Л.Ганчимэг: дэмжиж байнаа. ТУЗ-ын гишүүдийг сонгох шаардлагагүй гэж үзэж байна

Ж.Батсайхан: за тэгвэл ТУЗ-ийн ердийн гишүүнээр Ж.Баяраа, Ж.Баянтөр, Л.Ганчимэг, Б.Үүрийнцолмон, Б.Бямбадорж тэгээд миний биенийг сонгох, хараат бус гишүүнд Б.Баттулга, Б.Аюун, Б.Цолмонгэрэлийг сонгох санал хураалтаа явуулний.

Ж.Баяраа: За санал асуулга дууссан, саналаа хураая.

Б.Эрдэнэтуяа: Хувьцаа эзэмшигчдээс өгсөн зөвшөөрсөн санал нь компаний тухай хуулийн 63 дугаар зүйлд заасан хурлын шийдвэр хүчин төгөлдөр болох хувьд хүрсэн тул хурлын шийдвэрийг батлах тогтоолын төслийг хувьцаа эзэмшигчдэд танилцуулав. Зөвшөөрсөн 3437000 ширхэг хувьцаа буюу 79.09 хувиар батлав.

Ж.Батсайхан: хурлаас гарсан шийдвэрийг үндэслэн тогтоол дугаар -2 ийг уншив.

НЭГ: Кумлятив аргаар санал хураасан дүнг үндэслэн нэр бүхий 6 хүнийг компаний ТУЗ-ын ердийн гишүүнээр сонгосугай.

1. Ж.Баяраа
2. Ж.Батсайхан
3. Ж.Баянтөр

4. Л.Ганчимэг
5. Б.Үүрийнцолмон
6. Б.Бямбадорж

ХОЁР: Кумлятив аргаар санал хураасан дүнг үндэслэн нэр бүхий 3 хүнийг компаний ТУЗ-ын хараат бус гишүүнээр сонгосугай.

1. Б.Гантулга
2. Б.Цолмонгэрэл
3. Б.Аюуш

ГУРАВ: Компаний тухай хууль болон компанийн дүрмээр тогтоосон үүргээ хэрэгжүүлж, компанийн эрх ашгийн төлөө ажиллахыг гишүүдэд үүрэг болгосугай.

Хурлын дарга Ж.Батсайхан хэлэлцэх асуудал дууссан тул бүгдэд нь ажлын амжилт хүсэж хурлыг дуусгав.

Хурлын тэмдэглэл хөтөлсөн
Нарийн бичиг.....*Б.Батсайхан*..... / Б.Баярсайхан /



